



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/61

Мандалговь

┌ Дундговь аймгийн Стратеги хөгжлийн
загвар боловсруулах ажлыг хүлээн
авах комисс томилох тухай ┐

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1, 4.13 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Дундговь аймгийн Стратеги хөгжлийн загвар боловсруулах ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: О.Шинэжаргал (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Н.Мөнгөн (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Д.Нандинцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
нягтлан бодогч)

Б.Ууганбаяр (Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
багш)

Хоёр. Дундговь аймгийн Стратеги хөгжлийн загварыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

436190142